

**“СОНГИНО СУМ-ХЯРГАС НУУРЫН ЗҮҮН ХАЯА ЧИГЛЭЛИЙН 135.5 КМ ХАТУУ
ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ ТӨСӨЛ”-ИЙН КОНЦЕССЫН ГЭРЭЭНД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2019 оны 03 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

Энэхүү Гэрээ (цаашид “Нэмэлт гэрээ” гэх)-г Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135,5 км хатуу хучилттай авто зам төслийн концессын гэрээний 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн нэг талаас Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар /цаашид “Эрх бүхий этгээд” гэх/-ын дарга Б.Баярсайхан;

Нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан “Хос мөнгөн зам” ХХК, түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Баярсайхан /цаашид “Концесс эзэмшигч” гэх/ нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг байгуулав.

НЭГ. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

1.1. “Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135,5 км авто зам төсөл”-ийг хэрэгжүүлэх концессын гэрээний 1.7 дахь заалтын “2018” гэснийг “2019” гэж өөрчлөн найруулав.

ХОЁР. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Энэхүү Нэмэлт гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд “Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135,5 км авто зам төсөл”-ийг хэрэгжүүлэх концессын гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд концессын гэрээний хугацаанд адил хүчинтэй байна.

2.2. Энэхүү Нэмэлт гэрээг адил хүчинтэй 3 хувь үйлдэв.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ
ТӨЛӨӨЛЖ

Гарын үсэг:

Нэр: Б.Баярсайхан

Албан тушаал: Үндэсний хөгжлийн
газрын дарга

Тамга:



КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

Гарын үсэг:

Нэр: Б.Баярсайхан

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Тамга:

